



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/525

Баруун-Урт сум

Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх,
ашиглах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбилцол баталж, эрх олгох тухай” 65 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр баригдах Баруун-Урт-Сүхбаатар сум чиглэлийн 61.9 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг батлагдсан талбайн солбилцолын дагуу хайх, ашиглах зөвшөөрлийг авто замын ажлын гүйцэтгэгч “Монгол зам групп” ХХК-д олгосугай.

2. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг тухайн талбай хамаарах сумын Засаг даргатай гэрээ байгуулан орон нутагт төвлөрүүлж, нөхөн сэргээлтийг хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэн холбогдох мэргэжлийн байгууллага, сумдад хүлээлгэн өгч ажиллахыг “Монгол зам групп” ХХК (Ү.Батмөнх)-д үүрэг болгосугай.

3. Дээрх Авто замын барилгын төсөл үргэлжлэх хугацаанд түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглах зөвшөөрөл олгогдсон талбайд явуулж буй үйл ажиллагаанд холбогдох хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Г.Ганзориг), аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Ш.Нямхүү), Соёл урлагийн газар (Б.Золхүү), Баруун-Урт сумын Засаг дарга (Ж.Жавхаатөгс), Сүхбаатар сумын Засаг дарга (Б.Батхүрэл) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Х.Энхцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.ИДЭРБАТ



2224011311